



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/АЗС

Булган сум

Сумдын баяр наадмын хугацааг тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Засгийн газрын “Зарим аймгийн баяр наадмын хугацааг тогтоох тухай” 2024 оны 233 тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоолоор Булган аймгийн баяр наадмыг 2024 оны 07 дугаар сарын 07-08 ны өдрүүдэд, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/11 дүгээр тогтоолоор “Алтаргана-2024” наадмыг 2024 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд тус тус зохион байгуулахаар тогтоосонтой холбогдуулан сумдын баяр наадмыг 2024 оны 07 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд тэмдэглэхээр тогтоосугай.

2. Булган аймгийн Дашинчилэн, Бугат, Сайхан, Хангал, Хутаг-Өндөр, Рашаант сумдын тэгш ойн баяр наадмыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/03 дугаар тогтоолын дагуу тэмдэглэхийг дээрх сумын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ